

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт:

Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг УИХ-аар батлуулав.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгайлсан үйлчилгээ, арга хэмжээ бий болгох зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа.

“Ажиллах хүч харилцан солилцох тухай” Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газрын хоорондын хэлэлцээрт 2007 онд гарын үсэг зурсан бөгөөд хэлэлцээрийг батлах талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.

Төрийн албан хаагч болон төсөвт байгууллагад ажиллагчдын үндсэн цалинг эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшин, төсөвт байгууллагын зардлын хэмнэлттэй уялдуулж, 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 28.5 хувиар нэмэгдүүлж, төрийн албан хаагчдын дундаж цалинг 300.0 мянган төгрөгт хүргэх арга хэмжээ авлаа.

“Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай” УИХ-ын тогтоолыг гаргуулан 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэвэр 34500 төгрөг байсныг 41400 төгрөгөөр тогтоогоод байна.

“Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д өргөн бариад байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын баталсан “Үнийг тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний дагуу Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, хэрэглэгчийг үнийн зохиомол өсөлтөөс хамгаалах, бодит үнэ бүхий бараа, ажил үйлчилгээгээр хангагдах чиглэлээр хуульд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

Нийгмийн халамжийн багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг дагалдан гарах Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам, Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам, “Ахмадын сан” бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын төслүүдийг боловсруулаад байна.

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт заасны дагуу “Бүгд Найрамдах Солонгос улсын тэтгэврийн даатгалын сангаас шимтгэл буцаан авах эрх бүхий иргэдийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд хамруулах тухай журам”-ын төслийг боловсруулав.

1995 оноос өмнө Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтоолгосон иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай УИХ-ын 11 дүгээр сарын 30-ны өдрийн 88 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл болон “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтоолгосон иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын төслийг боловсруулаад байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, 2008 оны Төсвийн тухай хуулийн дагуу 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэв. Энэхүү арга хэмжээний дүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээ 20 хувь нэмэгдэх буюу бүрэн тэтгэврийн доод хэмжээ 81000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 54000 төгрөг тус тус боллоо.

Боловсролын салбарт:

“Хүүхэд бүрт нэг компьютер” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай харилцан ойлголцлын санамж бичгийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар хөтөлбөрийн туршилтанд Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 51, Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2-5

ангийн 776 сурагчдыг хамруулахаар туршилтыг зохион байгуулах багийн бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Улсын мэргэжлийн хяналтын газартай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцах, зөвлөн туслах хамтарсан ажлын багийг байгуулан нийслэлийн 5 дүүргийн 10 сургууль, 10 цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж, дүгнэлт гарган аймаг, нийслэлийн Боловсролын соёлын газрын дарга нарт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж хүргүүллээ.

“Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичиг хангалтын журам”-ыг батлав.

2008 оны 1 дүгээр сарын 15-18 өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Соёлын өдрүүдийг зохион байгуулсан бөгөөд Хятад, Монгол хоёр улсын соёл урлагийн солилцоо, хамтын ажиллагаа, ард түмний харилцан ойлголцол, найрамдлыг бэхжүүлэн хөгжүүлэхэд чухал арга хэмжээ боллоо.

Монгол Улсын нийгэм, улс төр, эдийн засгийн амьдрал, шинжлэх ухаан, соёл, урлаг, биеийн тамир, эрүүл мэндийн салбарт гарч байгаа түүхэн тэмдэглэлт онцгой үйл явдлыг архивлан хадгалах зорилгоор “Түүхийн хүрд” баримтат кино бүтээхэд зориулан 36.0 сая төгрөгийг улирал тутам хэсэгчлэн санхүүжүүлэхээр шийдвэрлэлээ.

“Шинжлэх ухаан, технологийн гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх үндсэн чиглэл” хөтөлбөрийг боловсруулж батлуулав. Энэ хөтөлбөр 2008-2015 онд хоёр үе шаттай хэрэгжинэ.

Монгол Улсын хөгжлийн гарцыг тодорхойлох, шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол улсын их сургууль, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, Нанотехнологи сантай хамтран “Нанотехнологи-2008” Үндэсний форумыг зохион байгууллаа.

Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Буриад Улсын Ерөнхийлөгч В.В. Наговицын тэргүүтэй төлөөлөгчдийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н. Болормаа хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр хоёр тал боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай санал солилцож, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын соёлын яам хооронд 2008-2010 онд хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам хооронд 2008-2010 онд хамтран ажиллах тухай протоколд хоёр тал гарын үсэг зурав.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдад сар бүр 45000 төгрөгийн тэтгэмж олгох тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулаад байна.

Эрүүл мэндийн салбарт:

“ХДХВ/ДОХ-ын хяналт, шинжилгээ, үнэлгээ” сэдэвт үндэсний зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ХДХВ/ДОХ-ын асуудлаархи тусгай хуралдаанаас гаргасан тунхаглалын хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлт, эрүүл мэндийн байгууллагуудаас ХДХВ/ДОХ-ын асуудлаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, эхээс хүүхдэд ХДХВ-ын халдвар дамжихаас сэргийлэх үйл ажиллагааг хянах үндсэн шалгуур үзүүлэлт зэргийг хэлэлцэн нэгдсэн зөвшилцөлд хүрлээ.

“Метанолын хордолтын үед авах яаралтай тусламж” эмнэлзүйн удирдамжийг боловсруулж Метанолын хордолтын үеийн бэлэн байдлыг хангах тухай Эрүүл мэндийн сайдын албан даалгаврын биелэлтийг шалгаж хяналт тавилаа.

Эрүүл мэндийн яам, “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллага хоорондын 2008-2012 онд хамтран ажиллах болон Сангийн яам, Эрүүл мэндийн яам, “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагын хооронд 2008-2009 онд хамтран ажиллах санхүүжилтын гэрээнд гарын үсэг зурав.

“Дэлхийн хүүхдийн байдал 2008” тайлан илтгэлийг хүлээн авах ёслолын арга хэмжээг Эх нялхсын эрдэм шинжилгээний төвд зохион байгуулав.

Вирус гепатит А голомтлон гарч байгаа нийслэлийн хүүхдийн байгууллагуудын халдвар хамгааллын дэглэмийг сайжруулах талаар зөвлөмж боловсруулж холбогдох байгууллагад хүргүүллээ.

Нийслэлийн Багануур дүүрэгт 2007, 2008 оны зааг дээр метанолын хордлогын улмаас 15 хүн эндсэн харамсалтай тохиолдол гарсантай холбогдуулан хордлоготой хүмүүсийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын дэмжлэгтэй зохион

байгуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх талаар Эрүүл мэндийн сайдын албан даалгаврыг хот, хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн ажилласнаар хордлоготой хүмүүс бүрэн эмчлэгдлээ.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын хордлоготой холбоотойгоор ирж ажилласан зөвлөхүүдийн зөвлөгөөний дагуу Хонгор сумын одоогийн байдал, цаашид гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гаргаж Засгийн газарт танилцуулан, орчны бохирдол, эрүүл мэндийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх орчны эрүүл мэндийн чиглэлийн мэргэжилтэн, хордлого судлаач, нарийн мэргэжлийн болон сэтгэл зүйч эмч нарын баг ажиллуулах хүсэлтийг ДЭМБ-д тавилаа. Гадны зөвлөх мэргэжилтнүүд манай эмч мэргэжилтнүүдтэй хамтран үнэлгээ хийн үзлэг зохион байгуулж, ялган оношлох, дагалдуулан сургах ажлыг хийж гүйцэтгэх юм.

Санхүү, эдийн засгийн чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газар, Мянганы сорилтын сангаар дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж буй АНУ-ын Засгийн газар хоорондын Мянганы сорилтын гэрээг УИХ-аар соёрхон батлуулав.

“Мянганы сорилтын сангийн гэрээний хэрэгжилтийн бэлтгэл ажлын тухай” Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Монголын мянганы сорилтын санг байгуулж, сангийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний саналын эрхтэй гишүүдийг батлахаар шийдвэрлэв.

Мөн Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпораци хооронд байгуулах Төслийн хэрэгжилтийг санхүүжүүлэх захидал гэрээ, олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгогдсон компаниудтай байгуулах Худалдан авах үйлчилгээний гэрээ болон Санхүүгийн үйлчилгээний гэрээнүүдэд гарын үсэг зурах бүрэн эрхийг Сангийн сайдад олгох тухай Ерөнхий сайдын захирамж гаргахаар болсон байна.

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн нийгэмлэг хооронд байгуулсан “Тогтвортой амьжиргаа-2” төслийн Санхүүжилтийн гэрээг УИХ-аар соёрхон батлууллаа.

Үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах Зөвлөлөөс хийсэн ажил, цаашид анхаарах асуудлын тухай Засгийн газрын хуралдаанд танилцуулсан байна. Үүнтэй холбогдуулан орон нутгаас авчирч Улаанбаатар хотод худалдаж байгаа махнаас хаврын хэрэгцээнд зориулан мах нэмж нөөцлөх, нөөцөд нэмж мах бэлтгэхэд төсвөөс зээл олгох, гаалийн татварын хувь хэмжээ тэг байх нөхцөлөөр импортоор оруулах гурилын хуваарьт тодотгол хийж орон нутагт гурилын хангамж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, нефть бүтээгдэхүүний импортын үнэ 2008 оны 1 дүгээр сараас нэмэгдсэнтэй холбогдуулан импортлогч компаниудад учирсан алдагдлыг нөхөхөд шаардлагатай 8.8 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн асуудлыг судалж шийдвэрлэх, нефть бүтээгдэхүүн, импортын гурил, улаанбуудай, хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлж байгаа тарифын бус зохицуулалтын журам, хураамж, төлбөрийн жагсаалтыг гаргаж хүчингүй болгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж эхэллээ.

Нисэх онгоцны буудал барих хэлэлцээрийн тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Сангийн сайдад олголоо. Японоос Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төслийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газарт 263.0 сая ам.доллартай тэнцэх хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн байна.

“Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр дөчин мянган орон сууц хөтөлбөрийг санхүүжүүлэх журам”-ыг шинэчлэн баталж, мөрдүүлэв.

Улсын төсвийн хөрөнгөөр 2008 онд хэрэгжүүлэх хот, хөдөөгийн 138 сургууль, цэцэрлэг, 51 соёлын төв, музейн их засвар, 65 эмнэлэг, спортын заалны их засвар, төв, орон нутгийн 81 засаг захиргааны конторын болон гадаад хэргийн 20 барилгын зэрэг нийт 17543.2 сая төгрөгийн их засварын ажлын жагсаалт, Улсын чанартай авто зам, гүүрийн засвар, арчлалтын ажлын 2008 оны төлөвлөгөөг баталж, нийтдээ улсын чанартай 52 төрлийн авто замын арчлалт, урсгал засварын ажлын болон 4 төрлийн гүүрийн их засвар, 9 төрлийн төсөл, арга хэмжээний зардалд 9014.5 сая төгрөг зарцуулахыг зөвшөөрсөн байна.

Өрхийн эмнэлгийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн хэмжээг баталж, 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдүүлж байна. Өрхийн эмнэлгийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн хэмжээг 0-5 хүртэлхи насанд гэр хороолд 13440, байшин хороололд 11760, 5-16 хүртэлхи насанд гэр хороолд 5460, байшин хороололд 5040, 16-49 насны эмэгтэйчүүдэд гэр хороолд 5880, байшин хороололд 5880, 60-аас дээш насанд гэр хороолд

8400, байшин хороололд 7560, бусад насанд гэр хороололд 4620, байшин хороололд 4200 төгрөг байхаар тус тус шинэчлэн тогтоосон байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2007 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж мэдээллээ. Үүнд:

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 1851.2 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг 147.2 тэрбум төгрөгөөр буюу 8.6 хувиар давуулан биелүүлж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 490.8 тэрбум төгрөгөөр буюу 36.2 хувиар илүү байна. Зарим барааны үнийн өсөлтийн албан татвараас 353.7 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлсний 90.3 хувийг буюу 319.5 тэрбум төгрөгийг “Эрдэнэт” улсын үйлдвэрийн газар зэсийн үнийн өсөлтийн татварын орлогоор оруулсан байна

Улсын нэгдсэн төсвийн зарлага 1749.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн нийт зарлагын 96.3 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 512.3 тэрбум төгрөгөөр буюу 41.4 хувиар илүү байна. Засгийн газар 2007 онд төрийн албан хаагчдын цалин, өндөр насны тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг удаа дараа нэмэгдүүлэх, улмаар нийгмийн халамж, үйлчилгээний нөхөн олговрын хэмжээг өсгөх дэс дараатай арга хэмжээ авсан явдал төсвийн зарлага нэмэгдэхэд голлон нөлөөлсөн төдийгүй цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеийнхээс 120.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 204.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд гүйцэтгэл 92.1 хувь, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар 161.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлж, гүйцэтгэл 87.4 хувьтай байна.

Монгол Улсыг хөгжүүлэх сангаас ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн санхүүжилтэд 12.4 тэрбум, 0-16 насны хүүхэд бүрт олгох мөнгөн тэтгэмжид 97.4 тэрбум төгрөг, зам тээвэр, түлш, эрчим хүчний салбарын их бүтээн байгуулалтын ба бусад салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 161.8 тэрбум төгрөг (нийт 271.6 тэрбум төгрөг) зарцуулсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн (өссөн дүнгээр) урсгал тэнцэл 482.2 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 102.2 тэрбум төгрөгийн ашигтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 411.7 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 97.9 тэрбум төгрөгийн ашигтай) гарсан байна.

Засгийн газрын нөөц сан, Монгол Улсыг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төсөв, түүний гүйцэтгэлийг хянаж, тайланг нэгтгэн гаргав. Засгийн газрын шийдвэрийн дагуу 2008 оны эхний сард Засгийн газрын нөөц сангаас 219.6 сая төгрөгийг зарцуулжээ. Мөн орон нутагт олгох НӨАТ-ын шилжүүлгээр 1899.2 сая, санхүүгийн дэмжлэгээр 1347.8 сая төгрөгийг хуваарилан олгов.

2008 оны эхний сард улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 769.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Үйлдвэр, худалдааны салбарт:

АНУ-ын Хөнгөлөлтийн Ерөнхий системд Монголын гар урлалын зарим бараа, бүтээгдэхүүн хамрагдах болсонтой холбогдуулан АНУ-ын Худалдааны яам болон Худалдааны төлөөлөгчийн газартай хамтран ажиллаж байна.

Засгийн газрын нээлттэй өдрийн арга хэмжээний хүрээнд Тусгай зөвшөөрөл, лицензийг цахим хэлбэрээр олгох систем нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, Тусгай зөвшөөрлийг Цахим хэлбэрээр олгох системийг олон нийтэд нээлттэй болголоо.

АНУ-ын ЭСЯ-тай хамтран Технологи дамжуулах тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар АНУ-ын Худалдааны яам, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай видео конференц хэлбэрээр холбогдож нэмэлт өөрчлөлтүүдийг хэлэлцэв.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэв.

АМГТХЭГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтцийг шинэчлэн баталлаа.

Цацраг идэвхт ашигт малтмал болон атомын эрчим хүч ашиглах талаар төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулаад байна.

Асгатын мөнгөний ордын материалыг нэгтгэн мэдээллийн сан байгуулж байна. Уг ордын асуудлыг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэв.

“Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” УИХ-ын 1998 оны 5 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах, Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар шийдвэрлэв.

Засгийн газрын 2007 оны 307 тоот тогтоолын дагуу нүүрснээс шатахуун гаргах үйлдвэр байгуулах төслийг төрийн оролцоотой хэрэгжүүлэх санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр бэлтгээд байна.

Газрын тосны нөөц бүрдүүлэлт хийх, Онцгой албан татварын тухай хууль болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах замаар газрын тосны бүтээгдэхүүний НӨАТ болон гаалийн татварыг 30 хоногийн дараа төлүүлэхээр өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-аар батлуулав.

Дорноговь аймгийн Замын-Үүд дэх шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийг АМГТХЭГ-т шилжүүлэх асуудлыг шийдвэрлэлээ.

Канад Улсын Олон улсын худалдааны сайд Дэвид Эмерсоны Айлчлалын үеэр Канадын Олон улсын худалдааны сайд Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхаж, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд, Үйлдвэр, худалдааны сайд нартай уулзалт хийсэн. Уулзалтуудын үеэр хоёр тал Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг байгуулах асуудлыг урагшлуулахаар тохиролцов. Хэлэлцээг энэ оны 3 дугаар сард Канадад эхлүүлэхээр тохиролцлоо.

“Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-ийг шинэчлэх ажлын хэсгийн боловсруулсан хуулийн төслийн талаар санал боловсруулж, холбогдох тооцоо судалгаа хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.

Согтууруулах ундаа худалдах цэгийн нормативийг өөрчлөх тухай Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 05 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын Худалдааны хэлэлцээрийг УИХ-ын Гадаад байдал, аюулгүй байдлын байнгын хороо болон УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлэв.

Байгаль орчны салбарт:

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аар батлууллаа. Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай, Байгалийн ургамлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-ын байнгын хороогоор хэлэлцүүлж эхлэв.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ан агнуурын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулаад байна.

2008 онд хийх ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын хуваарь, 2008 онд хэрэгжүүлэх ойг нөхөн сэргээх ажил, ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажил, ой зохион байгуулалтын ажлын хуваарийг боловсруулав. Энэ онд 8000 га талбайд улсын төсвөөр, 2500 га талбайд аж ахуйн нэгж байгууллагын өөрийн хөрөнгөөр, 265 га талбайд ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд ойжуулалтын ажил явуулахаар төлөвлөөд байна.

Байгаль орчны яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн хэрэг бүртгэх газрын хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх хамтарсан арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, хяналтын цэгүүд байгуулах тэдгээрийн үйл ажиллагаанд шаардагдах зардлын тооцоог хийж дуусгав.

Ой, усны хайгуул судалгааны төвөөс Хэнтий аймгийн ойн тархалтын зургийг өндөр нарийвчлалтай (1:50000) хийж, ойн нөөцийн бүх үзүүлэлтийн хамтаар гаргаж өгсөн нь ойг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг шинжлэх ухааны үндэстэй явуулах, нутгийн иргэдэд түшиглэсэн ойн аж ахуйн менежментийг хэрэгжүүлэх, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн үндсийг хангав.

БНСУ-ын Улаанбаатар хот дахь Ли Тэ Жүн эмчийн дурсгалд зориулан барьсан цэцэрлэгт хүрээлэнг Байгаль орчны яамны нэр дээр шилжүүлэн авах тухай гэрээнд гарын үсэг зурав.

Говь, хээрийн бүсэд хиймэл нуур, цөөрөм, усан сан, хөв байгуулах хайгуул, судалгааны ажлыг Ховд, Баян-Өлгий, Өвөрхангай, Баянхонгор, Хэнтий, Говьсүмбэр, Завхан

аймагт, говь, хээрийн бүсэд цас тогтоогч, лиман байгуулах хайгуул, судалгааны ажлыг Төв, Өвөрхангай аймагт тус тус гүйцэтгүүлэв.

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн бүртгэлийг шинэчлэн хийж, ЦЕГ-ын даргын тушаалаар улсын хэмжээнд хэрэгжиж эхлээд байгаа “Цохилт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлүүдийн эсрэг цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах төслийн ажлын хүрээнд Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 11 мянган өрхийг 33 000 тонн шахмал түлшээр, Баянгол дүүргийн айл өрхүүдийг 25000 тонн үртсэн шахмал түлшээр, Хан-Уул дүүргийн 100 өрхийг цахилгаан ялтсан халаагуураар, 8 сургууль, 6 цэцэрлэг, 50 өрхийн эмнэлгийн нам даралтын халаалтын зуухыг цахилгаан халаагуураар солих, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 1000 өрхийг гэрийн иж бүрэн дулаалгаар хангах ажлыг зохион байгуулж байна.

Ерөнхий сайдаас өгсөн үүргийн дагуу Улаанбаатар хотод зориулалтын бус зүйл түлж, агаар бохирдуулж байгаа зөрчлийг таслан зогсоох шалгалтын ажлыг Улсын мэргэжлийн хяналтын газар, Монгол телевиз, Өнөөдөр сонины газартай хамтран явуулав.

Эрдэс баялгийн олборлолтод эвдэрсэн, химийн хорт бодисоор бохирдсон талбайд үзлэг хийх, хэм хэмжээг тодорхойлох, бохирдлын хариуцагч, хор хохирлыг нь тооцож тогтоох зорилгоор Байгаль орчны яам, Үйлдвэр худалдааны яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын ерөнхий газар хамтарсан ажлын хэсгийг томилон 1 дүгээр сарын 22-ноос орон нутагт ажиллуулж байна.

Барилга, хот байгуулалтын салбарт:

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар “Хүн амыг орон сууцаар хангах, барилгын салбарт ажлын байр нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийн төслийг хэлэлцүүлээ.

Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, үүнтэй холбогдуулан Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн гзрын тогтоолын төслийг боловсруулав.

“Газар өмчлүүлэх болон эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааг явуулах журам”, “Газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”, Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох, бусдад шилжүүлэх, гэрчилгээний хугацаа сунгахад төлөх хураамжийн хэмжээ”, “Газрын мэдээллийн сангийн үйлчилгээний хураамжийн хэмжээг” тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэв.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн нийгэм, эдийн засаг, газар зүйн тандах судалгаанд Завхан, Төв, Архангай, Дархан-Уул аймгуудаас ирсэн саналыг тусгаж шинэчлэн боловсруулав.

Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн үзэл баримтлалыг дахин батлуулав.

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулав.

“40000 орон сууц” хөтөлбөрийн хүрээнд БХБЯ, ОХУ-ын Буриадын барилга, нийтийн аж ахуйн яамны хооронд байгуулсан санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ОХУ-ын бизнес групп манай улсад ажиллаж гэрээний төсөл дээр эцэслэн тохиролцов.

Буриад Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр хоёр орны Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны Протоколд барилгын салбарт хамтран ажиллах асуудлыг тусгав.

Зам, тээвэр, аялал жуулчлалын салбарт:

Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдэд танилцуулав.

“Далайн хиймэл дагуулын хөдөлгөөнт холбооны олон улсын байгууллага байгуулах тухай” 1976 оны "ИНМАРСАТ" конвенци, түүнийг хэрэглэх тухай протоколд /Лондон, 1976/ нэгдэн орох тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

“Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай” 1974 оны олон улсын конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1978 оны Протоколд нэгдэн орох тухай болон “Далайн олон улсын байгууллагын тухай” 1948 оны конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1993 оны Протоколд нэгдэн орох тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулав.

“Монгол Улсын Засгийн газар, Арабын Нэгдсэн Эмират Улсын Засгийн газар хооронд, тэдгээрийн нутаг дэвсгэрийн хооронд болон хилийн чанадад агаарын харилцаа байгуулах тухай” хэлэлцээрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн батлав.

Монгол Улсад ойрын болон дунд хугацаанд байгуулах төмөр замын сүлжээний чиглэл болон царигийн асуудлыг шинэчлэн боловсруулж Засгийн газрын хуралдаанаар оруулахаар бэлтгэж байгаа ба цаашид тээврийн үйлчилгээг улам боловсронгуй, хөнгөн шуурхай болгох зорилгоор гадаад худалдаа, олон улсын тээвэрлэлтийг хөнгөвчлөх талаар зарим арга хэмжээ авах асуудлыг боловсруулж байна.

“Баруун бүсийн автозамыг хөгжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулах буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн төслийг эцэслэн тохирч үзэглэсэн байна.

Монгол Улсын авто замын сүлжээг 2008-2016 онд хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан эргэн төлөгдөх нөхцөлөөр баригдах замуудын чиглэл, урт болон “Мянганы зам”-ын зүүн чиглэлд баригдах авто замын асуудлаар холбогдох шийдвэр гаргав.

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжих Ярант-Ховд чиглэлийн замын “Буцалтгүй тусламжийн гэрээний төсөл”-ийн саналыг Азийн хөгжлийн банкинд хүргүүлэв.

Улсын төсөв болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлав.

Мөн энэ онд Аялал жуулчлалын сан, улсын төсвийн хөрөнгөөр аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг баталлаа.

Аялал жуулчлалын салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор уулзалт зохион байгуулж, аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудлууд, шийдвэрлэх арга зам, цаашид хамтран ажиллах талаар ярилцав.

Мөн 2008 оны 2 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд болох “Мөсний баяр”, 2 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад суманд болох “Тэмээний баяр” зэрэг өвлийн аялал жуулчлалын арга хэмжээг Аялал жуулчлалын холбоо, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газраас Улаанбаатар хотод зохион байгуулсан “ӨМӨЗО-ныг сурталчилах өдөрлөг”-ийн хүрээнд уулзалт зохион байгуулж Монголын 20 гаруй аялал жуулчлалын компанийг оролцуулав.

БНХАУ, ОХУ болон бусад улсуудтай солилцдог улс хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийн зөвшөөрлийн хяналт, зохицуулалтын үүрэг, механизмыг дээшлүүлж, эдгээр зөвшөөрлийг зөвхөн Тээврийн үйлчилгээний төвтэй гэрээ байгуулсан, тээвэрлэлтийн стандарт, нөхцөл, шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн тээврийн хэрэгсэлд олгодог болгож, улс хоорондын тээвэрлэлтийн зөвшөөрлийн ашиглалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч байна.

Энэ оноос эхлэн монголын талын санал болгосноос илүү авсан ачаа тээврийн зөвшөөрлийн ширхэг тус бүрийг нь 3 ам.доллараар олгож байхаар ОХУ-тай тохирч протоколд гарын үсэг зурав.

Монгол, Хятадын хилийн тодорхой боомтуудаар хуваарийн бус цагаар үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийн дотроос Тээврийн үйлчилгээний төвтэй зохих гэрээ байгуулж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тээвэрлэлтийг хяналт, зохицуулалттайгаар зохион байгуулахгүй байгаа “Айвенхоу Майнз Монголия Инк”, Чинхуа-Мак-Нарийн сухайт” ХХК, “Петрочайна Дачин Тамсаг Монгол” компаниудыг уг жагсаалтаас хасах санал, үндэслэлийг боловсруулан Гадаад хэргийн яаманд хүргүүлэв.

Аймаг, орон нутгийн ахмад настнуудаас нийслэл хотод нийтийн тээврээр үнэгүй зорчих талаар удаа дараа гарч буй санал, хүсэлтийг үндэслэн “Нийтийн тээврээр үйлчлэх тухай” Зам, тээвэр, аялал жуулчлалын Сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжийн төслийг боловсруулаад байна.

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны комиссын Х дугаар хуралдааны

шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор болон Монгол Улс, БНХАУ хоорондын Иргэний агаарын тээврийн салбарын хамтын ажиллагааны хэлэлцээр хийх Ажлын хэсгийг Бээжин хотод томилон ажиллуулж байна.

Ирланд Улсын "CIT Aerospace International" компаниас "МИАТ" ХК-д ирүүлсэн Боинг-737-800W маягийн агаарын хөлгийн түрээсийн гэрээний төслийг судлан, санал дүгнэлт гаргах Зам, тээвэр, аялал жуулчлалын яам, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн өмчийн хороо, Иргэний нисэхийн ерөнхий газар, "МИАТ" ХК-ийн төлөөлөл бүхий ажлын хэсгийг томилон ажиллуулж, ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн агаарын хөлөг авч ашиглах асуудлаар холбогдох шийдвэрийг гаргууллаа.

Баян-Өлгийн чиглэлд нислэгийн тоог нэмэгдүүлэх, шуудан тээвэрлэлтийг цаг хугацаанд нь хүргэх болон Улаанбаатар-Арвайхээр-Хархорин-Улаанбаатар чиглэлд агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх асуудлыг судлан зохицуулах чиглэлийг Иргэний нисэхийн ерөнхий газарт өгөв.

"УБТЗ" Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн техник, технологийг шинэчлэх, дэд бүтцийг сайжруулах асуудлаар Монголын талын ажлын хэсгийг байгуулж Оросын талд албан ёсоор мэдэгдсэн. Хамтарсан ажлын хэсгийг хуралдуулах талаар Оросын талын ажлын хэсэгт удаа дараа хүсэлт тавьсан боловч асуудал шийдэгдээгүй тул I дүгээр улиралд хуралдуулах талаар дахин хүсэлт тавьсан болно.

"УБТЗ" ХНН-ийн хөдлөх бүрэлдэхүүний парк шинэчлэлийн хүрээнд шинээр 2 илчит тэргийг ОХУ-аас лизингээр, 16 шинэ суудлын вагоныг БНХАУ-аас худалдан авч ашиглаж эхэлсэн. Мөн хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх зорилгоор ОХУ-ын Төмөр замаас ашиглалтад байсан 350 ачааны вагоныг худалдан авах талаар гэрээ байгуулав.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх" төслийн Өргөн сум руу салсан туслах замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл аван "Shengli Engineering and Construction" Co., Ltd-тэй гэрээ байгуулав.

Булган-Уньт чиглэл дэх Булган-Гангатын хөтлийн 14.5 км хатуу хучилттай авто зам барих, баруун босоо тэнхлэгийн Ярант-Ховд чиглэлийн 112.2 км замын инженерийн нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэх зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээг дуусгав.

Улсын төсөв, замын сангийн хөрөнгөөр 2008 онд хийгдэх засвар, арчлалтын ажлын төлөвлөгөөг боловсруулан Сангийн сайд, ЗТАЖ-ын сайдын хамтарсан тушаалаар батлав.

Улаангом-Тээлийн гүүр чиглэлийн 15 км хатуу хучилттай авто зам, Сэлэнгэ мөрний Цацын булангийн 235 у/м төмөрбетон гүүр, Баянхонгор, Баян-Өлгий, Хөвсгөл, Дорнод, Төв, Булган аймгуудын улсын чанартай авто зам, замын байгууламжийг хариуцан ажиллах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг тус тус зарлав.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хөмүүлтэйн гүүрийн засварыг ажлыг гүйцэтгэх шууд гэрээг "Харгуй" ТӨҮГ-тай байгуулан ажлыг нь эхлүүлэв.

"Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн NP-2 багцын гүйцэтгэгчээр шалгарсан "Branch company No7of Road Construction "Wan Fa" (Shanghai) компанитай гэрээ байгуулах хэлэлцээр хийж байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн хуралдааныг Байгаль орчны яам, Германы техник, хамтын ажиллагааны нийгэмлэг, Дэлхийн байгаль хамгаалах сан зэрэг олон улсын байгууллага, төсөл хэрэгжүүлэх нэгжүүдтэй хамтран зохион байгуулав.

ОХУ-ын Москва хотноо зохиогдох "MITT-2008" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, Япон Улсын Токио хотноо зохион байгуулах "Глобальчлал ба экотуризм Монгол Улсад" олон улсын зөвлөгөөн, ХБНГУ-ын Берлин хотноо зохиогдох "ITB 2008" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагийн бэлтгэл ажлыг хангаж байна.

"Харилцаа холбооны зохицуулалт-2008" сэдэвт нээлттэй форумыг ХХЗХ-той хамтран зохион байгууллаа.

Шуудангийн сүлжээ, хүргэлтийн чиглэл, маршрутыг Монгол Улсын байр зүйн зурагт оруулан, шуудангийн сүлжээний төлөвлөлт, удирдлагад ашиглахад бэлэн болгов.

Түлш, эрчим хүчний салбарт:

“Хийн хангамжийн тухай” хуулийн төсөлд Эдийн засгийн байнгын хорооны санал, хуулийн заалтуудын тодотголыг тусган Улсын Их Хурлын ажлын хэсэгт танилцуулахад бэлэн болоод байна.

Түлш, эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулж байна.

Агаарын бохирдлыг бууруулах талаар хийж буй ажлын явц, ойрын хугацаанд авах арга хэмжээний тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.

Эгийн голын усан цахилгаан станцын төслийг БНХАУ-ын Засгийн газрын 300.0 сая ам. долларын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхтэй холбогдсон ажлыг зогсоох талаар Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж зөвшилцөхөөр тогтов.

Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн лицензийн маргаантай асуудлыг судалж, санал боловсруулах, хууль бусаар олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрлийн лицензийг хүчингүй болгох чиглэлээр ажиллаж байна.

Тамсагийн сав газрыг ашиглах, нүүрснээс шингэн түлш гаргах судалгаа, танилцуулгыг Хими технологийн хүрээлэнгийн эрдэмтэдтэй хамтран боловсруулж Ерөнхий сайдын дэргэдэх шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.

Ховд аймгийн Мянгад-Манхан, Манхан-Зэрэг, Зэрэг-Дарви, Манхан-Чандмань сумдын төвийг холбосон өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлыг дуусгаж, хүчдэл өгөх ажлыг зохион байгуулав. Мөн Увс аймгийн Улаангом-Малчин, Малчин-Хяргас, Хяргас-Баруунтуруун, Хяргас-Зүүнговь, Хөвсгөл аймгийн Арбулаг, Төмөрбулаг сумдын төвийг холбосон өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлыг дуусган хүчдэл өгөх ажлыг зохион байгуулж байна.

Говь-Алтай аймгийн эрчим хүчний үйлдвэрт дутагдаж байсан чадлыг нөхөх зорилгоор САТ фирмийн С-18 маркийн дизельгенератор суурилуулав. Мөн Завхан аймгийн эрчим хүчний үйлдвэрийн КАТ-3508 маркийн дизель генератор гэмтэж, Улиастай хотын эрчим хүчний хангамж доголдсон хүндрэлийг арилгахаар Ховд аймагт ашиглагдахгүй байгаа КАТ-3508 маркийн дизель генераторыг Улиастайд шилжүүлэх ажлыг зохион байгуулав.

2008 онд ОХУ-аас импортлох эрчим хүчний үнийг тохирч гэрээг байгуулав.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт:

Монгол Улсын Засгийн газраас 2008 оныг “Хүнсний хангамж, аюулгүй байдлын жил” болгон зарласантай холбогдуулан нээлтийн ажиллагааг Төрийн ордонд зохион байгуулав.

“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, Улсын тэргүүний тариаланч”-дыг тус тус шалгаруулан шалгарсан малчид, тариаланч, хамт олны шагналыг орон нутагт хүргүүлэх болон гардуулах ажлыг зохион байгууллаа.

“Атрын 3 дахь аян”-ы хүрээнд хэрэгжүүлэх стратеги, хөтөлбөр боловсруулах дэд хэсгүүдийг байгуулж, ажлын удирдамжийг батлав.

“Инком сат”, “Эс сайн” ХХК-иудын нийлүүлсэн бага оврын 673 тракторыг хүлээн авах ажлыг зохион байгуулав.

“Махны хангамж, нийлүүлэлт, нөөцлөлтийн тухай” Засгийн газрын албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нийслэлийн 6 цэгт 300 тн, хөдөө орон нутгаас 200.0 тн мах нийлүүлж, борлуулаад байна.

Улсын Байнгын Онцгой комиссын анхдугаар хуралдаанд “Адууны томуу өвчний цагийн байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх ажлын талаарх санал, дүгнэлт”-ийг асуудлыг хэлэлцүүлж зохих шийдвэр гаргуулан, биелэлтийг ханган ажиллаж байна.

ХХААЯ-ны Мал эмнэлгийн газар, ОБЕГ, УМХГ-ын хамтарсан ажлын хэсэг адууны томуу өвчний цагийн байдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, Архангай, Булган, Өвөрхангай, Төв аймгийн 13 суманд ажиллан мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Адууны томуу өвчнөөс сэргийлэх 3.165 литр буюу 632.9 мянган тун вакциныг бүх аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн албадад хүргүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайдын өгсөн үүргийн дагуу Дархан-Уул аймгийн Хонгор суманд ХХААЯ-ны Мал эмнэлгийн газар болон УМЭАЦТЛ, ХААИС-ийн МЭБС-ийн багш, мэргэжилтнүүд оролцсон ажлын хэсэг ажиллаж, шинжилгээнд дээж авч шинжлэхэд мөнгөн ус илрээгүй болно. Цаашид малын эрүүл мэндийн байдалд дүгнэлт гаргуулах зорилгоор Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын ХХАА-н байгууллага болон Олон

улсын цөмийн атомын энергийн байгууллагад малын эмч-хими, хор судлалын чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн хүмүүсийг урьж ажиллуулах хүсэлтийг тавиад байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Даян дэлхийн байгаль хамгаалах сангаас хамтран санхүүжүүлэх “Монгол Улсад Цөлжилттэй тэмцэх газрын тогтвортой менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх баримт бичигт гарын үсэг зурж, төслийг албан ёсоор эхлүүлэв.

Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран “Монголын төмсний салбарыг сэргээн сайжруулах хөтөлбөр”-ийн хоёрдугаар үе шат, Европын Холбооны хамтын ажиллагааны нийгэмлэгээс “Малын эрүүл мэнд ба мал аж ахуйн маркетинг” төслийг тус тус хэрэгжүүлж эхлээд байна.

Гадаад бодлогын чиглэлээр:

Ерөнхий сайд С.Баяр АНУ-ын Элчин сайд М.Минтоныг хүсэлтийнх нь дагуу хүлээн авч уулзав. Элчин сайд Ерөнхий сайдаар томилогдсонтой нь холбогдуулан АНУ-ын Ерөнхийлөгчөөс баяр хүргэж ирүүлсэн захидлыг гардуулж, харилцааны зарим асуудлаар санал солилцов.

Гадаад хэргийн дэд сайд АНУ-ын Элчин сайдыг хүлээн авч уулзан, Монгол Улсын зэвсэгт хүчний 9 дүгээр ээлжийн багийг Иракт илгээх тухай Засгийн газрын шийдвэрийг мэдээлж, энэ тухай ноотыг гардуулав.

“Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээ”-г Улсын Их Хурал соёрхон баталсан тухай ОХУ-ын ЭСЯ-нд ноот бичгээр мэдэгдэв.

Монгол-Британийн хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойг ИБУИНВУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-тай хамтран тэмдэглэв. Гадаад хэргийн сайд нарын хэмжээнд цахилгаан утас солилцож, МУИС-тай хамтран “Эрдэм шинжилгээний бага хурал” зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч БНСУ-ын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолд оролцохоор шийдвэрлэснийг БНСУ-ын талд албан ёсоор мэдэгдэв.

Ерөнхий сайд С.Баяр БНСУ-ын Элчин сайд Пак Жин Хуг өөрийнх нь хүсэлтээр хүлээн авч уулзан, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцож, БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах монгол ажилчдыг түргэн шуурхай явуулах талаар анхаарал тавих, 6 талт хэлэлцээний хүрээний Зүүн хойд Азийн энх тайван, аюулгүй байдлын асуудлыг хэлэлцэх ажлын хэсгийн уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулах тухай манай саналыг уламжилж, солонгосын талын дэмжлэгийг хүсэв.

Ерөнхий сайд С.Баяр, УИХ-ын дарга Д.Лүндээжанцан нар Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Я.Ичихаши-г өөрийнх нь хүсэлтээр хүлээн авч уулзав. Элчин сайд Хөшигтийн хөндийд шинэ нисэх онгоцны буудал барихад Япон Улсын Засгийн газар хөнгөлөлттэй зээл /28,8 тэрбум иен/ олгохоор шийдвэрлэсэн тухай мэдээлэхийн сацуу хоёр орны харилцааны бусад асуудлаар санал солилцов.

Ерөнхий сайд С.Баяр 6 талт хэлэлцээний хүрээнд зохион байгуулж буй Япон-БНАСАУ-ын харилцааг хэвийн болгох ажлын хэсгийн уулзалт болон Зүүн хойд Азийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны ажлын хэсгийн уулзалтыг Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулах санал тавьж, Японы талын дэмжлэгийг хүсэв. Мөн Хонгор сумын асуудал, улмаар ашигт малтмалыг буруу аргаар олборлосноос үүдэн гарч буй сөрөг үр дагаврын талаар тайлбарлаж, уг асуудлаар мэргэжлийн шинжээчид ирүүлэх хүсэлт тавьж, дэмжлэг хүсэв.

Япон Улсын Засгийн газрын 800.0 сая иенийн төслийн бус буцалтгүй тусламж авах тухай ноот бичигт Гадаад хэргийн сайд С.Оюун, Япон улсын Элчин сайд Я.Ичихаши нар гарын үсэг зурав.

“Цагаачлалын олон улсын байгууллагын дүрмийг соёрхон батлах тухай хууль”-ийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.

Батлан хамгаалах салбарт:

Сьерра Леон Улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд цэргийн багийн дараагийн ээлжийг бэлтгэж оролцуулах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэлээ.

“Иргэн цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ын болон “Цэргийн дүйцүүлэх албыг иргэн мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол”-ын төслийг боловсруулж, хэлэлцүүлэг хийхээр ажиллаж байна.

Зэвсэгт хүчний 2007-2008 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу офицер ахлагч нартай онолын мэдлэг олгох шатны сургалт, гэрээт цэргийн 1, 2 дугаар жилийн цэргийн албан хаагчидтай мэргэжлийн гүнзгийрүүлсэн сургалт, хугацаат цэргийн албан хаагчидтай мэргэжлийн бэлтгэл, салааны жигдрэлтийг хангах сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллав.

“Иракийн эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн баг, Сиерра Леон Улсад зохион байгуулж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цэргийн багийн бүрэлдэхүүнийг солих ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн тэсэрч дэлбэлэх зүйлийн хайгуул устгалын бүлэг Дулааны 3 дугаар цахилгаан станцад Багануурын нүүрсний уурхайгаас нүүрсэн дотор ачигдан ирсэн тэсрэх бодисыг аюулгүй болголоо.

ЗХЖШ-ын дарга ОХУ-д албан ёсны ажлын айлчлал хийж, ОХУ-аас Монгол Улсад буцалтгүй тусламжаар зэвсэг техник олгох хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Энэ удаагийн айлчлал нь Монгол Улс, ОХУ-ын цэргийн салбарын хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Хууль зүйн чиглэлээр:

Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, борлуулалт, үйлчилгээ, хэрэглээнд хяналт тавих тухай, Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын заавал даатгах даатгалын тухай, Зар сурталчилгааны тухай хуулийн төсөл болон тэдгээрийг дагаж гарах Харилцаа, холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг УИХ-д өргөн мэдүүлээд байна.

“Иргэний бүртгэлийг сайжруулах зарим арга хэмжээний тухай”, “Хөрөнгө гаргах тухай” Засгийн газрын тогтоолын, “Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэд, байгууллагад учирсан хохирлыг барагдуулах тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг тус тус боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

УИХ-ын гишүүн Х.Баттулгын санаачлан боловсруулсан Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд, УИХ-ын гишүүн А.Бакей, Г.Батхүү, Р.Буд нарын санаачлан боловсруулсан Бэлчээрийн тухай, УИХ-ын гишүүн Ц.Шаравдорж, Р.Амаржаргал нарын санаачлан боловсруулсан Өрсөлдөөний тухай, УИХ-ын гишүүн Х.Баттулгын санаачилсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, УИХ-ын гишүүн Л.Гантөмөрийн санаачилсан Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулийг хүчингүй болгох тухай, Орлогын албан татварын тухай хуулийн зарим зүйл заалтыг хүчингүй болгох тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Монгол Улсын татварын ерөнхий хуулийн зарим зүйл заалтыг хүчингүй болгох тухай, Авто замын тухай хуулийн зарим зүйл заалтыг хүчингүй болгох тухай зэрэг хуулийн төслүүд болон УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл, Р.Амаржаргал нарын санаачилсан Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, УИХ-ын гишүүн С.Баярцогт, Ц.Нямдорж, С.Оюун нарын санаачилсан Татварын өршөөлийн тухай хуулийн төсөлд өгөх Засгийн газрын санал дүгнэлтийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.

УИХ-ын гишүүн Ц.Сүхбаатар, Г.Батхүү, Ж.Гүррагчаа, Р.Раш, Ч.Содномцэрэн нарын санаачилсан “Төрийн албаны гавьяат ажилтан цол бий болгох тухай” УИХ-ын тогтоолын төсөл, УИХ-ын гишүүн Ц.Шаравдоржийн санаачилсан “Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төсөл зэрэг Засгийн газрын нийт 5 санал дүгнэлтийн төслийг бэлтгээд байна.

Монгол Улс, БНСУ хооронд “Ялтан шилжүүлэх тухай гэрээ”-г байгуулсантай холбогдуулан гэрээг соёрхон батлуулах тухай хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлал,

засгийн газрын хуралдааны тэмдэглэл, танилцуулгыг бэлтгэж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайдын 13 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас сар бүрийн 2 дахь долоо хоногийн мягмар гариг бүрт “Нээлттэй өдөр”-ийг зохион байгуулж байхаар боллоо.

Мөн нээлттэй өдрийн хүрээнд Нотариатын танхимын нотариатч нар иргэдэд үнэ төлбөргүй үйлчилж, Өмгөөлөгчдийн холбоо хууль зүйн зөвлөгөө өглөө.

Засгийн газрын 2007 оны 324 дүгээр тогтоолоор Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга нарт эрхэлсэн асуудал, чиг үүргийнхээ хүрээнд гаргасан нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэрүүдийг цэгцлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Уг тогтоолын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2007 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 161 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэг Хууль зүй, дотоод хэргийн сайдын дангаар болон хамтран баталсан Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй 170, бүртгэлгүй 8, нийт 178 шийдвэрийг хянан үзэж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дангаар батлан гаргасан 34 шийдвэрийг хүчингүй болгуулж, хамтран баталсан 26 шийдвэрийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар хүчингүй болгуулах шаардлагатай гэж үзэж холбогдох сайд нарт албан бичиг хүргүүллээ.

Монгол Улсад хууль бусаар хөдөлмөр эрхэлж байсан нь тогтоогдсон, Монгол Улсад оршин суух хугацаа нь дууссан боловч тус улсаас гарч явахаас зайлсхийсэн, Монгол Улсын хүн амын болон үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад харшилсан 6 улсын 613 иргэнийг Монгол Улсаас албадан гаргах асуудлыг шийдвэрлэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар